

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	14
3.4. Материаллаг байдал .....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	19
4. Менежментийн захидал .....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН  
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН  
ДАРГА, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
С.МӨНХБАТ ТАНАА

2021.02.25 № 07/491

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд, нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>196,985,728.51</b>	<b>393,920,902.61</b>
31	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	52,000.00	
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	52,000.00	
31110	Төгрөг	52,000.00	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
3121	Төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА	<b>6,317,471.50</b>	
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	6,317,471.50	
35	БАРАА МАТЕРИАЛ	<b>190,616,257.01</b>	<b>393,920,902.61</b>
35400	Хангамжийн материал	190,616,257.01	393,920,902.61
35410	Бичиг хэргийн материал	7,196,480.00	6,613,980.00
35420	Аж ахуйн материал	53,290,376.60	43,638,805.60
35440	Түлш, шатах тослох материал	140,000.00	1,820,000.00
35460	Хүнсний материал	2,736,081.00	5,605,419.60
35470	Бусад хангамжийн материал	127,253,319.41	336,242,697.41
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>8,373,459,346.97</b>	<b>8,760,576,079.91</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,373,459,346.97	8,760,576,079.91
39200	Биет хөрөнгө	7,718,003,935.93	8,068,921,768.87
39201	Барилга, байгууламж	7,689,952,576.59	7,689,952,576.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	(256.683.178.68)	(513,366,357.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	150,517,320.00	166,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл-Тээврийн хэрэгсэл	(144,280,338.36)	(94,820,312.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,574,614,472.76	2,238,325,832.76
39206	Хуримтлагдсан элэгдэл- Тоног төхөөрөмж	(1,429,288,703.26)	(1,530,282,671.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	388,222,090.02	398,507,490.02
39208	Хуримтлагдсан элэгдэл- Тавилга	(279,621,097.14)	(311,020,582.88)
39217	Номын фонд	24,570,794.00	24,875,794.00
393	Биет бус хөрөнгө	<b>655,455,411.04</b>	<b>691,654,311.04</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	675,634,858.00	713,033,758.00
39304	Хасагдуулга	(20,179,446.96)	(21,379,446.96)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>8,570,445,075.48</b>	<b>9,154,496,982.52</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	<b>272,900.00</b>	<b>160,878.18</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	272,900.00	160,878.18
413	Өглөг	272,900.00	160,878.18
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		6,999.18
4136	Бусад өглөг	272,900.00	153,879.00
41361	Байгууллагад төлөх өглөг	272,900.00	153,879.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>8,570,172,175.48</b>	<b>9,154,336,104.34</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,570,172,175.48	9,154,336,104.34
51100	ЗГ-ын оруулсан капитал /ЗГ-ын сан/ орон	2,346,405,152.09	2,346,405,152.09

	нутгийн сан		
51101	Өмч: төрийн өмч	2,346,405,152.09	2,346,405,152.09
	Хуримтлагдсан үр дүн	(1,637,227,050.32)	(1,053,063,121.46)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,637,227,050.32)	(1,636,244,315.56)
51220	Тайлант үеийн үр дүн		583,181,194.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,860,994,073.71	7,860,994,073.71
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИН ДҮН (VI=IV+V)</b>	<b>8,570,445,075.48</b>	<b>9,154,496,982.52</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,036,900,900.00</b>	<b>3,101,464,410.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>21,032,000.00</b>	<b>986,447,910.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	21,032,000.00	986,447,910.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,032,000.00	986,447,910.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,099,500.00	5,712,260.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,932,500.00	980,735,650.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,015,868,900.00</b>	<b>2,115,016,500.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,015,868,900.00	2,112,616,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,015,868,900.00	2,112,616,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>2,400,000.00</b>
ДТ(131105)	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,400,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,131,400,983.91</b>	<b>2,519,400,594.24</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,131,400,983.91	2,519,400,594.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,086,616,215.91	2,249,965,106.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	594,984,758.25	1,237,764,238.29
210101	Үндсэн цалин	443,342,358.25	789,603,050.29
210102	Нэмэгдэл цалин	88,730,600.00	359,243,888.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,931,800.00	45,917,300.00
210104	Урамшуулал	34,980,000.00	43,000,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл</b>	<b>71,887,600.00</b>	<b>153,708,025.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	48,883,600.00	106,661,811.58
210202	Тэтгэмжийн даатгал	5,751,000.00	12,493,861.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,600,800.00	9,914,065.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,150,200.00	2,236,047.90
210205	Эрүүл мэндийн даатгал	11,502,000.00	22,402,238.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,250,228.22	304,966,646.12
210301	Гэрэл, цахилгаан	13,877,804.80	23,043,223.80
210302	Түлш, халаалт	138,675,813.42	266,583,472.32

210303	Цэвэр, бохир ус	13,696,610.00	15,339,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,851,022.00	39,567,471.00
210401	Бичиг хэргийн материал	9,236,490.00	9,156,838.00
210402	Тээвэр, шатахууны зардал	3,095,000.00	3,619,764.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,519,532.00	7,472,600.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	3,846,700.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	-	15,471,569.00
2105	Норматив зардал	16,426,089.50	15,644,098.40
210501	Эм	135,000.00	842,100.00
210502	Хоол	14,757,969.50	14,798,998.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,533,120.00	3,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,537,960.00	30,371,942.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	24,400.00
210604	Урсгал засвар	21,537,960.00	30,347,542.00
2107	Томилолт, зочны зардал	1,449,840.00	603,000.00
210702	Дотоод томилолтын зардал	1,449,840.00	603,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,158,297.00	32,094,301.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,437,500.00	28,309,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	963,297.00	820,968.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	652,500.00	739,333.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	105,000.00	105,000.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	-	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	182,070,420.94	435,245,384.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,557,217.00	39,694,079.25
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	157,513,203.94	395,551,305.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,784,768.00	269,435,487.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,784,768.00	166,667,579.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,577,428.00	40,504,959.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,057,340.00	72,659,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	150,000.00	53,502,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	102,767,908.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	102,767,908.74
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(94,500,083.91)</b>	<b>582,063,815.76</b>
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	<b>4,400,000.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	4,400,000.00
5	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>3,282,621.66</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,282,621.66
6	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6)=(4-5)</b>	-	<b>1,117,378.34</b>
7	<b>НИЙТ ҮР ДҮН (7)=(3)+(4)</b>	<b>(94,500,083.91)</b>	<b>583,181,194.10</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,782,945,400.00</b>	<b>2,120,728,760.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,527,500.00	5,712,260.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,527,500.00	5,712,260.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	34,527,500.00	5,712,260.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,527,500.00	5,712,260.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,748,417,900.00</b>	<b>2,115,016,500.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,748,417,900.00	2,112,616,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,748,417,900.00	2,112,616,500.00
	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>2,400,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,400,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,771,847,900.00</b>	<b>2,120,345,460.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,771,847,900.00	2,120,345,460.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,662,998,793.00	1,851,063,851.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,043,654,000.00	1,231,439,767.61
210101	Үндсэн цалин	741,820,300.00	769,114,558.61
210102	Нэмэгдэл	172,126,200.00	373,407,909.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,727,500.00	45,917,300.00
210104	Үр дүнгийн урамшуулал	77,980,000.00	43,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,103,200.00	152,725,290.28
210201	Тэтгэврийн даатгал	86,430,100.00	105,679,076.82
210202	Тэтгэмжийн даатгал	10,168,300.00	12,493,861.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,134,600.00	9,914,065.10
210204	Ажилгүйдлийн даатгал	2,033,700.00	2,236,047.90
210205	Эрүүл мэндийн даатгал	20,336,500.00	22,402,238.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	276,849,892.00	304,966,646.12
210301	Гэрэл, цахилгааны зардал	25,017,062.00	23,043,223.80
210302	Түлш, халаалтын зардал	229,756,420.00	266,583,472.32
210303	Цэвэр, бохир усны зардал	22,076,410.00	15,339,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,421,364.00	48,477,609.25
210401	Бичиг хэрэг	2,945,200.00	2,182,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,200,000.00	5,118,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,737,854.00	7,472,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	968,000.00	6,269,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,570,310.00	27,434,109.25
22010310	Нормативт зардал	36,076,595.00	22,692,637.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	482,945.00	1,196,800.00
210502	Хоол, хүнс	30,473,400.00	17,910,437.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,120,250.00	3,585,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,596,552.00	2,789,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,639,300.00	1,282,100.00
210604	Урсгал засвар	14,957,252.00	1,507,500.00
	Томилолт, зочны зардал	2,436,900.00	603,000.00
210702	Дотоод албан томилолт	2,436,900.00	603,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,629,897.00	33,242,201.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,494,400.00	28,771,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	963,297.00	820,968.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	658,000.00	739,333.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	105,000.00	105,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	409,200.00	805,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,230,393.00	54,127,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	99,230,393.00	54,127,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,849,107.00	269,281,608.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,706,988.00	166,513,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,577,428.00	40,351,100.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,598,560.00	72,659,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	4,531,000.00	53,502,900.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,142,119.00	102,767,908.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,142,119.00	102,767,908.74
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,097,500.00</b>	<b>383,300.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>		<b>4,400,000.00</b>
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		4,400,000.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	11,045,500.00	4,835,300.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	11,045,500.00	4,835,300.00
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	11,045,500.00	4,835,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,045,500.00	4,835,300.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	(11,045,500.00)	(435,300.00)
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>52,000.00</b>	<b>(52,000.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	52,000.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	52,000.00	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>2,346,405,152.09</b>	<b>7,860,994,073.71</b>	<b>-1,458,987,641.15</b>	<b>8,749,081,526.65</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,346,405,152.09</b>	<b>7,860,994,073.71</b>	<b>-1,458,987,641.15</b>	<b>8,749,081,526.65</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			-94,500,083.91	-94,500,083.91
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,346,405,152.09</b>	<b>7,860,994,073.71</b>	<b>-1,637,227,050.32</b>	<b>8,570,172,175.48</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			982,734.76	982,734.76
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,346,405,152.09</b>	<b>7,860,994,073.71</b>	<b>-1,636,244,315.56</b>	<b>8,571,154,910.24</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			583,181,194.10	583,181,194.10
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,346,405,152.09</b>	<b>7,860,994,073.71</b>	<b>-1,053,063,121.46</b>	<b>9,154,336,104.34</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,122,616,500.00</b>	<b>2,020,012,851.26</b>	<b>102,603,648.74</b>	<b>95.2%</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,122,616,500.00</b>	<b>2,020,012,851.26</b>	<b>102,603,648.74</b>	<b>95.2%</b>
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>1,956,102,800.00</b>	<b>1,853,499,151.26</b>	<b>102,603,648.74</b>	<b>94.8%</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,258,836,700.00	1,231,439,767.61	27,396,932.39	97.8%
Үндсэн цалин	815,512,800.00	769,114,558.61	46,398,241.39	94.3%
Нэмэгдэл	313,616,400.00	373,407,909.00	(59,791,509.00)	119.1%
Унаа болон бусад нөхөн олговор	51,727,500.00	45,917,300.00	5,810,200.00	88.8%
Урамшуулал	77,980,000.00	43,000,000.00	34,980,000.00	55.1%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,943,000.00	152,725,290.28	17,217,709.72	89.9%
Тэтгэврийн даатгал	119,589,500.00	105,679,076.82	13,910,423.18	88.4%
Тэтгэмжийн даатгал	12,588,400.00	12,493,861.48	94,538.52	99.2%
ҮОМШӨ-ний даатгал	10,070,700.00	9,914,065.10	156,634.90	98.4%
Ажилгүйдлийн даатгал	2,517,700.00	2,236,047.90	281,652.10	88.8%
Эрүүл мэндийн даатгал	25,176,700.00	22,402,238.98	2,774,461.02	89.0%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	342,569,900.00	304,966,646.12	37,603,253.88	89.0%
Гэрэл, цахилгаан	26,316,600.00	23,043,223.80	3,273,376.20	87.6%
Түлш, халаалт	281,764,600.00	266,583,472.32	15,181,127.68	94.6%
Цэвэр, бохир ус	34,488,700.00	15,339,950.00	19,148,750.00	44.5%
Хангамж, бараа материалын зардал	49,361,800.00	49,357,609.25	4,190.75	100.0%
Бичиг хэрэг	2,182,900.00	2,182,900.00		100.0%
Тээвэр, шатахуун	5,118,700.00	5,118,700.00		100.0%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,472,600.00	7,472,600.00		100.0%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,269,300.00	6,269,300.00		100.0%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,318,300.00	28,314,109.25	4,190.75	100.0%
Нормативт зардал	41,638,800.00	22,692,637.00	18,946,163.00	54.5%
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,196,800.00	1,196,800.00		100.0%
Хоол, хүнс	36,856,300.00	17,910,437.00	18,945,863.00	48.6%
Нормын хувцас зөөлөн эдлэл	3,585,700.00	3,585,400.00	300.00	100.0%

Эд хогшил худалдан авах	2,828,500.00	2,789,600.00	38,900.00	98.6%
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,321,000.00	1,282,100.00	38,900.00	97.1%
Урсгал засвар	1,507,500.00	1,507,500.00		100.0%
Томилолт, зочны зардал	603,000.00	603,000.00		100.0%
Дотоод албан томилолт	603,000.00	603,000.00		100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,690,700.00	33,242,201.00	1,448,499.00	95.8%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,919,800.00	28,771,000.00	1,148,800.00	96.2%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	2,000,000.00		100.0%
Даатгалын үйлчилгээ	980,000.00	820,968.00	159,032.00	83.8%
Тээврийн хэрэгслийн татвар	880,000.00	739,333.00	140,667.00	84.0%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	105,000.00	105,000.00		100.0%
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	805,900.00	805,900.00		100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	55,630,400.00	55,682,400.00	(52,000.00)	100.1%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,630,400.00	55,682,400.00	(52,000.00)	100.1%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	166,513,700.00	166,513,700.00		100.0%
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	166,513,700.00	166,513,700.00		100.0%
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,351,100.00	40,351,100.00		100.0%
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	72,659,700.00	72,659,700.00		100.0%
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	53,502,900.00	53,502,900.00		100.0%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,122,616,500.00	2,019,960,851.26	102,655,648.74	95.2%
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,112,616,500.00	2,014,248,591.26	98,367,908,74	95.3%
Улсын төсвөөс санхүүжих	2,112,616,500.00	2,014,248,591.26	98,367,908,74	95.3%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	10,000,000.00	5,712,260.00	4,287,740.00	57.1%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	5,712,260.00	4,287,740.00	57.1%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		52,000.00	(52,000.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	
Төсвийн бусад мэдээллийн ангилал				
Ажиллагсдын тоо	91	89	2	97.8%
Удирдах ажилтан	1	1		100.0%
Гүйлчлэх ажилтан	48	46	2	95.8%

Үйлчлэх ажилтан	42	42		100.0%
Орон тооны мэдээлэл				
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/				

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		2,400,000.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		2,400,000.00
Бараа, үйлчилгээний зардал		2,400,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		2,400,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,400,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		2,400,000.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		2,400,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,400,000.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг С.Мөнхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт /и баримт/-ыг авч хэвших, шилэн дансны болон худалдан авах ажиллагааны цахим хуудсанд орлого зардлын мэдээллийг тогтмол байршуулж хэвших талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Их Наяд Аудит” ХХК-ний Захирал Х.Ариунзул хянан удирдаж, чанарын хяналт хэрэгжүүлэх, Ахлах аудитор М.Мөнхзул, Аудитор М.Энхтуул, Туслах С.Бямбацэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Их Наяд Аудит” ХХК-д 2021 оны 01-р сарын 14-ний өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Нийгмийн түншлэл, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлж, хувь хүний чадамжинд суурилсан, мэдээллийн технологид тулгуурласан, ирээдүйг угтсан, насан туршийн боловсрол олгох сургалтын тогтолцоог бий болгож, сургалтын орчныг сайжруулан, багшлах боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, төлөвшсөн, чадварлаг мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд оршино.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн түншлэл ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэх
- Төгсөгчдийг ажлын байраар хангах
- Сургалтын орчинг сайжруулах
- Багшлах боловсон хүчний чадавхийг үе шаттайгаар дээшлүүлэх
- Гадаад харилцаагаа өргөжүүлж, төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр материаллаг байдлын буруу илэрхийллийн дүн ба шинж байдлыг хоёуланг нь харгалзан үзэх үүднээс өөдрөг үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,103,178.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 42,063.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзэн 2020 оны суурь үзүүлэлт болох санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,522,683.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 50,453.7 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 584,051.9 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	52.0	-	(52.0)
Авлага	6,317.5	-	(6,317.5)
Урьдчилгаа			
Бараа материал	190,616.3	393,920.9	203,304.6
Үндсэн хөрөнгө	8,373,459.3	8,760,576.1	387,116.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,570,445.1</b>	<b>9,154,497.0</b>	<b>584,051.9</b>
Өр төлбөр	272.9	160.9	(112.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,570,172.2	9,154,336.1	584,163.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>8,570,445.1</b>	<b>9,154,497.0</b>	<b>584,051.9</b>

Авлага дансны үлдэгдэл 6,317.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны татварын байгууллагаас авах авлагыг тайлант онд суутган тооцсон нь нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 393,920.9 мянган төгрөг болж 203,304.6 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны 3243 дугаар зээл “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд Интер сайнс” ХХК, “Медимпекс интернэшнл” ХХК, “Түүлс маркет” ХХК, “Хашхан” ХХК-ниас хандив тусламжаар 199,620.3 мянган төгрөгийн бараа материал авсанаас шалтгаалжээ.



Бараа материалын дансны үлдэгдэлийн 1.7 хувь буюу 6,614.0 мянган төгрөгийг бичиг хэргийн материал, 11.0 хувь буюу 43,638.8 мянган төгрөгийг аж ахуйн материал, 0.5 хувь буюу 1,820.0 мянган төгрөгийг түлш шатах тослох материал, 1.4 хувь буюу 5,605.4 мянган төгрөгийг хүнсний материал, 85.4 хувь буюу 336,242.7 мянган төгрөгийг бусад хангамжийн материал тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,760,576.1 мянган төгрөг болж 387,116.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 4,835.3 мянган төгрөг, Азийн хөгжлийн банкны 3243 дугаар зээл “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Интер сайнс” ХХК, “Медимпекс интернэшнл” ХХК, “Түүлс маркет” ХХК, “Хашхан” ХХК, “Бодь электроникс” ХХК “МБ инженеринг” ХХК-ниас хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 743,716.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 493 тогтоолын дагуу акталсан 58,017.3 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн биет бус хөрөнгө 37,398.9 мянган төгрөгөөр өсч, тайлант онд байгуулсан 1,200.0 мянган төгрөгийн элэгдэлээр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 160.9 мянган төгрөг болж 112.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өрийг төлж барагдуулсанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,154,336.1 мянган төгрөг болж 584,163.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,064,563.5 мянган төгрөгөөр буюу 1.9 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төвлөрсөн төсөв 1,096,747.6 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 2,400.0 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 976,803.1 мянган төгрөгөөр өссөн ба үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих нь 11,387.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 1,387,999.6 мянган төгрөгөөр буюу 1.9 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт өссөнөөс зардлууд өссөн үзүүлэлттэй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,122,616.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,122,616.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад 364,198.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 2020 оны 01-р сарын 01-нээс эхлэн багш ажилчдад төрд ажилласаны нэмэгдэл цалинг ажилласан жилээс хамаарч 25 хувь хүртэл тооцон олгох, Азийн хөгжлийн банкний хөрөнгө оруулалтаар хичээлийн 2 байр 2020 оны 9 сард ашиглалтанд орохтой холбоотой байр ашиглалтын зардал, дотуур байранд суудаг оюутны 1 өдрийн хоолны нормыг Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 04 өдрийн № 83 тоот тогтоолоор норматив зардал, Ковид-19 цар тахлын улмаас

холбогдон гарах зардал, МСҮТ -ийн багш нар 5-н жил тутамд авдаг тэтгэмжийн зардал нь тэтгэмж авах хүний тооноос шалтгаалж, цахилгааны багш А.Гомбо нь ажил дээрээ нас барсан ба ар гэрт олгох тэтгэмж өссөнтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 33 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,122,616.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,112,616.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 10,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,112,616.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,712.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө борлуулсны орлого 4,400.0 мянган төгрөг нийт 2,122,728.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 52.0 мянган төгрөг байсан ба урсгал үйл ажиллагаанд 2,020,012.8 мянган төгрөгийг зарцуулж 102,768.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 4,287.7 мянган төгрөгөөр тасарсан нь түр сургалтуудыг Ковид-19 цар тахлын улмаас зохион байгуулж чадаагүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,020,012.8 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 27,396.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 17,217.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 37,603.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 4.2 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 18,946.2 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 38.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зардлыг 1,448.5 мянган төгрөгөөр хэмнэсэн ба бараа үйлчилгээний бусад зардлыг 52.0 мянган төгрөгөөр илүү зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн зардал дутуу зарцуулагдсан нь Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио хийгдсэнээс ажилчдын ажилчдын илүү цагийн хөлс, багц цагийн хөлс, шалгалтын цагийн хөлс, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар баригдсан барилга нь 2020 оны 09 сард ашиглалтанд орох төлөвлөгөөтэй байсан боловч 2021 оны 01 сард ашиглалтанд орсонтой холбогдон байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, дотуур байрны оюутан сурагчид дотуур байрандаа 10 сар суух байтал 2.5 сар суусан тул нормативт зардал, шинэ байр хугацаандаа ашиглалтанд ороогүй тул бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал тус тус хэмнэгдсэнээс шалтгаалан 4 хөтөлбөрийн 7 арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас нэмэлт санхүүжилтээр 2,400.0 мянган төгрөгийн орлогыг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл, хугацаа хоцроосон 12 мэдээлэл, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллийн тулгалтаар нийт 13,053.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг байршуулахдаа 6,984.0 мянган төгрөгийн орлого дутуу ба таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний зардлыг байршуулахдаа 6,069.0 мянган төгрөгөөр дутуу мэдээллийг оруулсан байна.

Гарсан зөрчлийг аудитын илрүүлэлт болон менежментийн захидалд тусгасан.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,236.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 3,050.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 93.3 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Биелэлтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	2	2,236.2	2	2,236.2	-	-	100
Албан шаардлага	1	3,050.0	1	3,050.0	-	-	100
Зөвлөмж	3	-	3	-	-	-	93.3
Нийт дүн		<b>5,286.2</b>		<b>5,286.2</b>			

/мянган.төгрөг/

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31,825.1 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 6,752.5 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 13,053.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2,284.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 9,735.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын данснаас бусад хангамжийн материалыг түүвэрлэн шалгахад ашиглалтад байгаа хангамжийн материалыг шууд зарлагдсан 6,752.5 мянган төгрөгийн зөрчил гарсаныг залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Залруулагдаагүй алдаа, зөрчлөөс 2,284.6 мянган төгрөгийн зөрчлийг төлбөрийн акт тогтоож, 13,053.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшилын тооцооллыг давтан шалгахдаа нийт 100 ажилчдаас 47 ажилчдыг түүвэрлэн шалгахад нийт 1,784.6 мянган төгрөгийн илүү цаг тооцож илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д батлагдсан

төсвийг зориулалтын дагуу зарцуулах Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ" 20 дугаар зүйлийн 20.2.4.нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тушаалаар ашиглалтын хугацаа дууссан 2 ширхэг автомашиныг нийт 4,900.0 мянган төгрөгөөр борлуулсныг тайланд 4,400.0 мянган төгрөгөөр тусгаж 500.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан нь Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 төсвийн орлого, зарлага хөрөнгө өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж тайлагнах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга, үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоох

3. Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,984.0 мянган төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,069.0 мянган төгрөгийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний зардлын нийт 13,053.0 мянган төгрөгийн мэдээллийг дутуу байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, иж бүрэн батламж мэдэгдлүүд хангагдахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 9,735.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *Зардлын данстай холбоотой асуудал*

###### 1.1. Илрүүлэлт:

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ 9,318.6 мянган төгрөгийн /и баримт/-ыг аваагүй, баримтын бүрдэлийг ханган ажиллаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй хангагдахгүй байна.

###### 1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль, тогтоомжийг мөрдөхгүй байх.

###### 1.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт /и баримт/-ыг авч, борлуулагч байгууллагад цахим баримтын системд баримтыг оруулах шаардлага тавьж хэвших

###### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аж ахуй нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ /И баримт/-ын бүрдлийг хангаж ажиллана.

##### *2.Зардлын данстай холбоотой асуудал*

###### 2.1. Илрүүлэлт:

Жижиг мөнгөн сан данснаас 416.4 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй хангагдахгүй байна.

###### 2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль, тогтоомжийг мөрдөхгүй байх.

###### 2.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт /и баримт/-ыг авч хэвших

###### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: <b>2020.12.31</b>	Аудитын нэр:	<i>Налайх дахь, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ</b>		САГ-2021/105/СТА-ТШЗ
			Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ 9,318.6 мянган төгрөгийн /и баримт/-ыг аваагүй, баримтын бүрдэлийг ханган ажиллаагүй	9,318.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Л.Пүрэвжаргал
2	Жижиг мөнгөн сан данснаас 416.4 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн байна.	416.4	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Л.Пүрэвжаргал
3	www.shilendans.gov.mn цахим хуудасны тулгалтаар нийт 13,053.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг байршуулахдаа 6,984.0 мянган төгрөгийн орлого дутуу, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний зардлыг байршуулахдаа 6,069.0 мянган төгрөгөөр дутуу мэдээллийг оруулсан байна	13,053.0	Албан шаардлага	Нягтлан бодогч	Л.Пүрэвжаргал
4	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшилын тооцооллыг давтан шалгахдаа нийт 100 ажилчдаас 47 ажилчдыг түүвэрлэн шалгахад нийт 1,784.6 мянган төгрөгийн илүү цаг тооцож илүү олгосон байна.	1,784.6	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	С.Мөнхбат Л.Пүрэвжаргал
5	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тушаалаар ашиглалтын хугацаа дууссан 2 ширхэг автомашиныг нийт 4,900.0 мянган төгрөгөөр борлуулсныг тайланд 4,400.0 мянган төгрөгөөр тусгаж 500.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна.	500.0	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	С.Мөнхбат Л.Пүрэвжаргал
<b>ДҮН</b>		<b>25,072.6</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25 № 22/А0160060  
СМ-2021/СТА-ТЦЗ  
105/

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн нийт 100 ажилчдаас 47 ажилчдыг түүвэрлэн шалгахад хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйгээс нийт 1,784.6 мянган төгрөгийн илүү цагийг ажилчдад илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" ЗГ-ын 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3-д "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн ажилчдад олгосон илүү цагийн 1,784,591.00 /нэг сая долоон зуун наян дөрвөн мянга таван зуун ерэн нэг / төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 /аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар холбогдох дансаа бичнэ/ тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв"-ийн дарга С.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Л.Пүрэвжаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
"ИХ НАЯД АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЦЭРЭНДОРЖ  
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Газар22.Docx

001090453



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25 № 21/АО160060  
СЭГ-2021/105/СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлага худалдаагаар ашиглалтын хугацаа дууссан 2 ширхэг автомашиныг нийт 4,900.0 мянган төгрөгөөр борлуулсныг тайланд 4,400.0 мянган төгрөгөөр тусгаж, 500.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна.

Энэ нь Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага хөрөнгө өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж тайлагнах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дуудлага худалдааны орлогын дутуу тусгасан 500.000 /таван зуун мянган/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 /аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар холбогдох дансаа бичнэ/ тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв"-ийн дарга С.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Л.Пүрэвжаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

"ИХ НАЯД АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЦЭРЭНДОРЖ

Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2021\0225auditln 2-R Gazar21.Docx

001090451





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 64/АД160060  
С.М.-2021/105/СТА-ТЦЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаа хоцроосон 12 мэдээлэл мөн нийт 13,053.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв"-ийн дарга С.Мөнхбат, ерөнхий нягтлан бодогч Л.Пүрэвжаргал нарт хариуцуулав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

"ИХ НАЯД АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЦЭРЭНДОРЖ

Х.АРИУНЗУЛ





